

Монгол, Солонгос хэлний амьтдын дуугарах дуу авианы нэрийн ажиглалт

Бүддоржийн ПҮРЭВСАН*

Олон Улсын Улаанбаатар их сургуулийн докторант

Хураангуй

Бодит ертөнцийн юмс, үзэгдлийн дуу авиаг хэлэнд авиа дуурайх үгээр дуурайн тэмдэглэдэг. Ингээж тэмдэглэхдээ байгалийн тодорхой нэг дуу авиаг хэл бүрд янз бүрээр тэмдэглэдэг ба энэ нь тухайн дуу авиаг хэрхэн сонсож мэдэрсэнтэй үлэмж холбоотой юм. Жишээлбэл: нохой хуцах дууг монгол хэлэнд “хав хав”, орос хэлэнд “гав гав”, япон хэлэнд “わん [wan]”, солонгос хэлэнд “멍멍 [meongmeong]” гэх мэт.

Авиа дуурайх үг нь хүүхдийн анх сурах үг, түүний хэлбэр бүтэцтэй адилхан байдаг. Тиймээс бага насны хүүхдүүд авиа дуурайх үгийг их хэрэглэдэг төдийгүй ан амьтдын нэрийг тэдгээрийн дуугарах дуу авиагаар нь нэрлэх явдал ажиглагддаг.

Монгол хэлэнд амьтдын дуугарах дуу авиаг авиа дуурайх үгээр хэрхэн тэмдэглэдэг болохыг тус хэлний тайлбар толь, дуурайх үгийн тольд тулгуурлан шүүн түүвэрлэж тэдгээрийн бүтэц, хэв шинж, онцлогийг судлах явцдаа солонгос хэлэнд амьтдын дуу авианы нэрийг хэрхэн тэмдэглэдэг болохыг мөн ажигласан болно.

Амьтдын дуу авиаг дуурайн тэмдэглэсэн авиа дуурайх үг монгол хэлэнд дан буюу давтсан хэлбэрээр орж тухайн амьтны нэг удаагийн болон удаан үргэлжлэх дуу авиаг илтгэхээс гадна дуу авиа үүсгэгч эзэн олон буйг авиа сэлгэн илэрхийлдэг онцлогтой байна. Мөн авиа дуурайх язгуур дээр үйл үг бүтээх дагавар залган амьтдын дуугарах дуу авиаг үйл үгээр илэрхийлдэг онцлогтой байхад солонгос хэлэнд амьтдын дуу авиаг тэмдэглэх нь монгол хэлтэй харьцуулахад бага байгаа бөгөөд, ингэхдээ давтсан бүтэцтэй авиа дуурайх үгээр амьтдын дуу авиаг ихэвчлэн дуурайн тэмдэглэдэг болох нь ажиглагдлаа.

Түлхүүр үг: ан гөрөөсний, шувууны, мал, тэжээмэл амьтны, жижиг амьтны дуу авиа, монгол, солонгос хэлний авиа дуурайх үг

* © Б.Пүрэвсан 2024

E-mail: purevsan@ulaanbaatar.edu.mn

Удиртгал

Хүн төрөлхтөн бодит ертөнцийн юмс, үзэгдэл, тэдгээрийн дуу чимээ, олон янз байдал болон хэлбэр дүрс, шинж чанарыг мэдрэхүйн эрхтнээрээ дамжуулан хүлээн авч тэрхүү мэдрэмжээ хэлэнд ерөнхийлөн дуурайж тэмдэглэхдээ дуурайх үгээр тэмдэглэх нь олонтоо. Дуурайх үг нь хүний 5 мэдрэхүйн үйлчлэлтэй холбоотой ба өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн байгалийн олон янзын дуу авиаг сонсох мэдрэхүйгээр тус бүрээр нь ялган сонсдог ч тэр чигээр нь хэлэнд буулгалгүй авиа дуурайх үгээр; харин харах, үнэрлэх, амтлах, хүртэх мэдрэхүйд тулгуурлан мэдэрдэг мэдрэмжээ хэлэнд дүрс дуурайх үгээр тэмдэглэдэг.

Аливаа хэлний үгийн санд байгалийн элдэв үзэгдэл, хүн амьтан, араатан жигүүртэн зэргээс гарах элдэв янзын дуу авиаг дуурайх, хэлэхүйн авиагаар тэмдэглэсэн үг арвин бий. Ингэж хэлэхүйн авиагаар байгалийн дуу авиаг тэмдэглэхдээ тэр чигээр нь биш, ерөнхийлөн дуурайн тэмдэглэхдээ авиа дуурайх үгээр тэмдэглэдэг.

Авиа дуурайх үг гэдэг нь англи хэлээр “onomatopoeia” бөгөөд энэ нь грек хэлний ‘ονοματοποιία’ -гэдгээс үүссэн үг юм. Үүнийг ‘ὄνομα (onoma = "нэр")’ болон ‘ποιέω (poieō = "бүтээх" эсвэл "хийх")’ гэсэн үгээр орчуулж болох бөгөөд “нэр бүтээх” гэсэн утгатай юм. Мөн “imitating sounds” хэмээн нэрлэдэг (Д.Төмөртоогоо, 2004:11) бөгөөд үүний утга нь “дуурайсан дуу авиа” гэсэн үг.

Эрдэмтэн А.Шлейхер “Бүх хэлний эхлэл нь юу вэ гэвэл янз бүрийн байдлаар хэрэглэгддэг байсан ойлголт, төсөөлөл, сэтгэгдлийг тэмдэглэсэн ерийн авиа болон утга бүхий авианууд байсан юм гэж хэлж болно” (Coare Василе, 1997:13) гэсэн нь хэлийг авиа дуурайх үгээс үүссэн гэх онолыг баталсан хэрэг юм. Ийм ч учраас авиа дуурайх үг нь тухайн хэлний уугуул үгс болдог. Эдгээр үгсийг хэл бүрд өөр өөрөөр тэмдэглэдэг ба зарим дуу авиаг хэл бүрд яг ижил биш боловч ойр төстэй авианы бүтцээр тэмдэглэдэг нь тэрхүү дуу авиаг хэрхэн сонсож мэдэрч байгаа тухайн улсын хүмүүсийн соёл сэтгэлгээ болон хэлний авиатай холбоотой гэж үзэж болох юм.

Амьтнаас ялгарах өвөрмөц дуу чимээ нь ямар нэг утгыг ямагт илэрхийлдэг. Жишээлбэл, муур зулзагатайгаа харилцахдаа дор хаяж арван өөр дуу авиа ашигладаг бөгөөд энэ дуу авиа нь шаардлага, урам зориг, заналхийлэл, энхрийлэл, заавар, уриа гэх мэт тус бүрдээ онцгой утгатай байдаг. (И.А.Бодуэн де Куртенэ, 1963:261)

Монгол, солонгос хэлэнд байгалийн элдэв янзын дуу авиаг дуурайн хэлний авиагаар тэмдэглэсэн авиа дуурайх үг арвин байдаг ба эдгээрээс амьтдын дуугарах дуу авиаг хоёр хэлэнд хэрхэн дуурайн тэмдэглэдэг болохыг судалсан болно. Ингэхдээ хоёр хэлний тайлбар толь болон дуурайх үгийн толь бичгээс шүүн түүвэрлэж улмаар тус хоёр хэлэнд амьтдын дуу авиаг дуурайн тэмдэглэсэн үг тоо хэмжээний хувьд ямар байгааг, мөн тэдгээр үгийн бүтэц, хэв шинжийн онцлогийг тодорхойлох зорилго тавин судалсан болно.

1. Монгол хэлний амьтдын дуугарах дуу авианы нэр

Монгол хэлэнд эрдэмтэд авиа дуурайх үгийг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, хэл шинжлэлийн бусад асуудлыг хөндсөн судалгаандаа авиа дуурайх үгийг дүрс дуурайх үгтэй хамтад нь өгүүлсэн байдаг. Тухайлбал, *Монголч эрдэмтэн Т.А.Бертагаев (1974) дуурайх үгийг байгалийн авиа болон харааны сэрэлд өртсөн юмыг авиагаар дуурайн дүрсэлдэг, ямар нэг утга илтгэдэг хэмээн тодорхойлоод, эдгээр үгсийг нэрлэх үүрэггүй гэж; М.Халтод (1973) Олон улсын монголч эрдэмтдийн II их хуралд “Монгол хэлний үйл үгийн язгуур үндэс дэх авиа дуурайх авиа” хэмээх илтгэлдээ монгол хэлний авиа дуурайх үгсийг хүний, малын, араатан амьтны, байгалийн үзэгдлийн, бодис юмны гэж 5 ангилаад “-ги, гинагна, -гир-, -гоо, -год, -жигна, -л, -на, -р, -тна, -хил, хина, -хир, -чигна, -ш, -шир” зэрэг 17 дагавраар бүтсэн сонсох мэдрэлд сэрэгдэх 200–аад үгийг бүртгэн “Монгол үгний үйл үгийн язгуур үндэс дэх авиа дуурайх үгс “Э, ЭГ, ГЭ, ГЭГ” гэх мэт нэг үеэр бүтжээ” гэж; Академич Ш.Лувсанвандан (1968) “Монгол хэлний нөхцөлгүй үгийн дотор үйл хөдлөл, дуу авиаг чихэнд сонсогдох, нүдэнд үзэгдэх, биед хүртэгдэх байдлыг дүрслэн үзүүлсэн үгс ихээхэн суурийг эзэлнэ” хэмээгээд, дуу чимээний үгс гэдэг нь үнэндээ чихэнд сонстох дуу чимээг ч дүрслэн үзүүлэх үгсээр хязгаарлагдахгүй, мөн нүдэнд харагдах, биед хүртэх үйл хөдөлгөөний янз бүрийн байдлыг дүрслэн үзүүлэх бүлэг үгс юм гэж; Т.Доржсүрэн (1969) “Монгол хэлний дуу чимээ дуурайсан үгийн тухай” өгүүлэлдээ дуу чимээ дуурайх үгс нь ихэвчлэн битүү үеэр төгсөх ба үе төгсгөж буй гийгүүлэгч нь утга ялгаруулах чухал үүрэгтэй гээд, “н” төгсгөл нь цуурайтай буюу хөндий юмны унах, цохих зэрэгт үүсэх авиаг “г” төгсгөл нь хатуу юм агшин зуур хүчтэй мөргөлдөхөд үүсэх авиаг дуурайдаг гэж; Ш.Барайшир (1970) дуу чимээ, дүр байдал илтгэх үгсийг нийтэд нь дуу чимээний үг гэж нэрлэж ирснийг шүүмжилж, “Эдгээр үгс нь зөвхөн дуу чимээ илэрхийлэх бус басхүү дүр байдал илтгээж байгаа учир тэдгээрийг дуу чимээний үгс гэх нь тохиромжгүй учир эдгээр үгсийг нийтэд нь дүрслэх дайвар үг гэх нь зүйтэй” гэж; Г.Гэндэнсүрэн (1973) “Орчин цагийн монгол хэлний дүрс байдал үзүүлсэн үг нь хүн, амьтны үйл хийгээд алив юмны дүр төрх, өнгө зүс, дуу чимээ, хөдлөл, байдал, шинж чанар гэхчлэн тал бүрийн үзэгдэл юманд хамрагдан хэрэглэгдэх утга учрыг заадаг” гэж; Ц.Өлзийхутаг (1979) “Монгол хэлний “маа, маа, мөө, мөө, мяу, мяу, гаа, гаа, гуаг, гуаг” зэрэг үгс нь нэг талаар сэтгэлийн хөдөлгөөн илтгэх ба бусдад хандсан утга илтгэх аялга үг, өгүүлбэрийн шинжтэй, нөгөө талаар амьтдын дууг дуурайн хэлсэн тул авиа дуурайсан үгийн шинжтэй гээд дээрх үгсийг дуу чимээ дуурайсан үг гэж; Б.Бямбасүрэн, Ц.Жанчивдорж нар (1980) “Монгол хэл” сурах бичигтээ малыг тэжээж арчлах, эдэлж хариулах, ивэлгээж хөхүүлэх зэрэгтэй холбогдсон үг монгол хэлэнд элбэг байхаас гадна, аливаа амьтан юмны дуу чимээг дуурайсан үгс ч байдаг. Эдгээр нь гадна байдлаараа аялга үгтэй төстэй боловч, хүний*

сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлэгддэггүй үгс юм гээд, “мяу-мяу, гүүг-гүүг, зуу-зуу, чар чар” зэрэг жишээ авч тайлбарласан байна. (М.Базаррагчаа, 1987:78-85)

Эрдэмтэн М.Базаррагчаа “Хэл нь юмс үзэгдлийг дуурайн, уг зүйлийг хэвээр нь тусгадаг. Үүнд дүрслэх ба авиа дуурайх үгс хамаатай юм гээд, монгол хэлний дүрслэх үг нь нүдтэй, авиа дуурайх үг нь чихтэй тус тус холбогдох ба нүднээ үзэгдэх дүрслэлээс үүдэн аманд мэдрэгдэх “дарвигнах” гэх мэт үг дам үүсжээ” гэж үзсэн бол эрдэмтэн Ц.Өнөрбаян “Монгол хэлэнд хүн амьтан, юмс үзэгдлийн бүдүүн, өтгөн дуу авиаг чанга <а, у, о>, нарийн, шингэн дуу авиаг эм сул <э, ү, и>, удаан үргэлжлэн уянгалсан дуу авиаг урт, хос эгшиг оролцуулан тэмдэглэж утга ялгадаг” (Ц.Өнөрбаян, 2004:71) гээд, “Монгол хэлэнд өгүүлбэр ба өгүүлбэрийн аль нэг гишүүний ерийн утгыг төрөл бүрийн баймж утгаар нэмэн дэлгэрүүлэх үүрэгтэй, нэр үг, үйл үгтэй холбогдож дуу чимээ, үйл хөдөлгөөний олон янз байдлыг дүрслэх үүрэгтэй үгийг дүрслэн чимдэг үгс” гээд эдгээр үгсээ дотор нь болц байдлыг дүрслэн чимэх үгс, дуу авиа дуурайн чимэх үгс гэж ангилжээ. (Ц.Өнөрбаян, 2004:328) Харин эрдэмтэн Ш.Барайшир “Дуу чимээ, дүр байдал илтгэх үгсийг голдуу дуу чимээний үг гэж нэрлэж ирсэн байна. Эдгээр үгс нь зөвхөн дуу чимээ илэрхийлэх бус басхүү дүр байдал илтгэж байгаа учир тэдгээрийг дуу чимээний үгс гэх нь тохиромжгүй бөгөөд, эдгээр дуу чимээ, дүр байдал илтгэх үгсийг нийтэд нь дүрслэх дайвар үг гэх нь зүйтэй гээд, эдгээр үг нь үйл байдлын дуу чимээ, хөдөлгөөн зэргийг нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдон, сэтгэл санаанд сэрхийтэл дүрслэн гаргадаг үгс” (Ш.Барайшир, 1970:93) хэмээн тус тус тодорхойлжээ.

Алтайн хэлнүүдэд үг бүтэх ёс нь авиа дуурайх үгстэй ихээхэн холбоотой бөгөөд амьтдын нэрийн ихэнх нь авиа дуурайж нэрлэсэн үг байдаг гэж монголч эрдэмтэн Г.И.Рамстедт үзжээ. (Г.И.Рамстедт, 1957:223)

Амьтны дуугарах дуу авиаг ан гөрөөсний дуу авианы нэр, шувууны дуу авианы нэр, мал, тэжээмэл амьтны дуу авианы нэр, мэлхий, хорхой, ялаа, батгана, царцаа зэрэг амьтны дуу авианы нэр гэж ангилан монгол хэлний шим ертөнцийн дуу чимээний нэрсийг судалсан Жамцын Бадраа гуайн тухай нийтлэлч, хэл шинжлэлийн ухааны доктор М.Саруул-Эрдэнэ “Зугаатай хэл шинжлэл” нэртэй монгол хэл сонирхогчдын нүүр номын бүлгэмд дурдсаныг харан түүнээс санаа авч, улмаар энэхүү ангиллын дагуу “Монгол хэлний их тайлбар толь, Дүрслэх үгийн тайлбар толь”-оос амьтдын дуу авианы нэрийг болон дуугарах үйлийн нэрийг түүж нэгтгэлээ. Үүнд:

Хүснэгт 1. Ан гөрөөсний дуу авианы нэр

Ан гөрөөсний дуу авиаг тэмдэглэсэн үг	Толь бичгийн тайлбар
<i>биад биад</i>	илий, янгуудай, янзага зэргийн нялх амьтдын дуугарах дуу
<i>гиар гиар</i>	үнэг, өмхий хүрэн зэрэг амьтны хүний өөдөөс эсэргүүцэх дуу чимээг дуурайсан үг
<i>жиад жиад</i>	самжийн дуу

<i>миа миа</i>	илий буюу бугын зулзага, янгуудай буюу зүрийн зулзага, туулай зэрэг амьтны цухалдан дуугарах дуу
<i>чар чар</i>	суусар дуугарах
<i>архирах</i>	араатан амьтны бүдүүн дуугаар хүрхрэн ярдаглах дуу, чоно шүдээ ярзайлган архиран дайрахад бэлдэх дуу, баавгай их дуугаар архирах
<i>архиралдах</i>	арслан барсын олноороо зэрэг зэрэг дуугарах дуу
<i>хүрхрэх</i>	арслан, барс зэргийн нүсэр амьтдын цээжээ хүржигнүүлэн дуугарах
<i>урамдах</i>	буга, бухын хангинан дуугарах
<i>урхирах</i>	арслан, барс зэрэг том амьтны архиран урагш тэмүүлэн дуугарах
<i>улих</i>	чоно, нохой зэрэг амьтны урт удаанаар гиншиж гэнгэнэн дуугарах
<i>хурхирах</i>	буга, зүр зэрэг амьтны холоос хүн амьтны бараа харж, сэжиглэн дуугарах
<i>хошихрох</i>	тарвага, гургуул зэрэг амьтан дуугарах

Дээрх хүснэгтээс ажиглавал, илий буюу бугын зулзага, янгуудай буюу зүрийн зулзага зэрэг жижиг амьтдын нарийн, шингэн дуу “биад биад, гиар гиар, жиад жиад, миа миа” гэх зэрэг тагнайшсан гийгүүлэгчээр эхэлсэн үг зонхилж байна. Мөн нялх амьтад эхийгээ эрэн дуудахдаа нэг удаа дуугараад зогсолгүй, үргэлжлүүлэн тасралтгүй давтан дуугарах тохиолдол их байдаг. Ийнхүү амьтны тасралтгүй дуугарах дууг монгол хэлнээ давталтын аргаар илэрхийлдэг онцлогтой байна. Харин арслан, бар, баавгай, чоно зэрэг том биетэй, сүр хүчтэй араатан амьтдын дууг чанга эр <а, у> эгшиг болон чичрэх, шүргэх “-р” гийгүүлэгчээр голдуу тэмдэглэсэн байна.

Монгол хэлнээ авиа дуурайх үгийг давтан хэрэглэхийн зэрэгцээ эгшиг ба гийгүүлэгчийг сэлгүүлэн хоршиж, дуу чимээний үргэлжлэн давтагдах, өнгө өөрчлөгдөх болон олон юмны нийлбэр авианы төрхийг илтгэдэг (М.Базаррагчаа, 1987:139) онцлог байдаг. Үүнийг шувууны дуу авиа дуурайх үгийн жишээгээр харуулбал,

Хүснэгт 2. Шувууны дуу авианы нэр

<i>Шувууны дуу авианы нэр</i>	<i>Толь бичгийн тайлбар</i>	<i>Шувууны дуугарах үйлийн нэр</i>
<i>гаага ггаага</i>	хэрээ, тахиа зэргийн дуугарах дууны аялга	<i>гаагалах</i>
<i>ган ган</i>	усны шувуу ганганан дуугарах дуу /ангир/	<i>ганганах, аагинах</i>
	галуу шувуу уйтгартай дуугарах дуу	<i>гангинах</i>
	олон галуу уйтгартай дуугарах дуу	<i>гангиналдах</i>
<i>ган гун</i>	олон усны шувууд алсад ганганан дуугарах	<i>ганганалдах</i>
<i>гун ган</i>	хээрийн галууны дуу	<i>ганганан гунганах</i>
<i>гангар гунгар</i>	нүүдлийн шувууд дуугарах дуу	
<i>голин галин</i>	алтан гургалдайн дуу	
<i>гоог гоог</i>	тахианы дуугарах дуу	<i>гооглох</i>
	галуу шувуу дуугарах дуу	<i>гааглах</i>
<i>гооггор гооггор</i>	тогоруу шувуу дуугарах дуу	<i>гуруйлах</i>

гоод хорд	хун цэнгийн дуу	хуугинах
гуаг гуаг	хэрээний дуугарах дуу	гуаглах
гуад гүэд	нугасны дуу	нуугих
гүүг гүүг	хөхөөний дуугарах дуу	гүүглэх
гиаг гиаг	харцгай, хяргуйны дуугарах дуу /махчин шувуу/	гиаглах
жан жин	шувуу ижлээ эрж дуугарах дуу	
жиар жир	олон бялзуухай нисэн дуугарцгаах дуу	
жив жив	жигжиг шувуудын дуугарах дуу	жиргэлдэх
жир жир	болжмор зэрэг жигжиг шувууны дуугарах дуу	жиргэх
жигэр жигэр	шаазгайн дуу	шаагирах
жсйд жсйд	зулзага шувуу эхээ эрэх дуу	
жингэр жингэр	гургуул шувууны дуугарах дуу	
жун жун	цахлай шувууны дуугарах дуу	
нугар нугар	нугар шувууны дуугарах дуу	
увааг увааг	том шувууны дуугарах дуу	
хон хон	хэрээ шувууны өлсгөлөн дуугарах дуу	
	бүргэдийн дуугарах	бөөрөх, хагиших
	шувууны уянгалан дуугарах /хөхөө/	донгодох
	богширго, хараацай, шар цэгцгийн дуугарах	жиргэх
	үхэр цууцал дуугарах	ийглэх
	сүрэглэсэн бялзуухайн дуугарах	цурхих
	шаазгайн дуугарах	шаагиших, шаниших
	ангир шувууны дуугарах	аагинах
	бөднө шувууны дуугарах	бөөтнөх
	элээ шувууны дуугарах	янцгаах
	бөөөөлж шувууны дуугарах	бөөөөлөх
	тагтааны дуугарах	хүхтнэх
	шар шувууны дуугарах	хүүгнэх

Эндээс харахад, шувуудын дуу авиаг “гааг гааг, гиаг гиаг, жив жив” гэх мэт авиа дуурайх үгийг давтан хэрэглэж тухайн дуу авианы үргэлжлэн давтагдах дуу чимээг тэмдэглэсэн бол “гангар гунгар, жан жин” гэх мэт эгшиг авиа сэлгүүлж шувуудын олон янзын дуу авианы нийлбэрийг тэмдэглэсэн байна.

Шувуу судлалын ухаанд жигүүртэн шувууг дотор нь зэрлэг шувуу, махчин шувуу, хээрийн шувуу, гэрийн шувуу, нүүдлийн шувуу, усны шувуу, нуурын шувуу гэх мэт ангилдаг бөгөөд Монгол оронд 500-аад нэрийн шувууд байдаг¹. Дээрх хүснэгтийн дагуу шувууны дуу авиаг монгол хэлэнд олон янзаар тэмдэглэж байгаагаас гадна хээрийн, нүүдлийн болон усны шувуудын дуу авиа дуурайх үгийн бүтцэд чанга <а, у, о> эгшиг зонхилж байгаагаас гадна <г> гийгүүлэгч авиагаар эхэлсэн жишээ элбэг байна. Харин болжмор, бялзуухай зэрэг шувуудын дуу авианы нэрийн бүтцэд эм сул <и> эгшигтэй, <ж> гийгүүлэгч авиагаар

¹ <http://www.touristinfocenter.mn/catell1.aspx>

эхэлсэн жишээ элбэг байгаа нь жижиг шувуудын жиргэх дууг ингэж тэмдэглэдэг онцлогтой болохыг илтгэж байна. Уран зохиолд голдуу нүүдлийн шувуудын дуу авиаг дуурайх үгээр урин дулааны улирал болон цагийн сайхныг дүрсэлж хүмүүсийн сэтгэлд таатай сайхнаар мэдрүүлдэг онцлог байна. Тухайлбал,

- 1. *Хээрийн галуу айлчлан ирж гангар гунгар донгодохуйяа*
Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна. (Д.Н)
- 2. *Зуны найртай улирал дор цэцэг навчин дэлгэрээд*
Жигүүртэн шувуун холоос ирж гангар гунгар донгодсон орон (Д.Н)

Амьтны дуу авианы зүйлд таван хошуу малын дууг дуурайсан үг хэллэг монгол хэлнээ нэн элбэг. Энэ нь уламжлалт нүүдлийн аж ахуйтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуй нь бусад аж ахуйгаас ялгарах гол онцлог нь элдэв ааш араншинтай амьтантай харьцдаг учраас тэдгээрийг өөр хооронд нь ялгах, ааш араншинд нь тохируулах адуулах, тэдний дуу чимээнээс аюул зэрэг элдэв дохиог хүлээн авч сэрэмжлэх зэргээр тэднээс гарах дуу авианы ялгамжийг нарийн мэдрэх шаардлага зүй ёсоор гардаг. Иймээс монгол хэлэнд таван хошуу малын дуу авиа гарах үйлийг тэмдэглэсэн “янцгаах, үүрсэх, майлах, мөөрөх” гэх мэт олон үг бий. Мөн түүнчлэн малын дуу авиаг дуурайн дүрсэлсэн “май май, ий ха ха, өмбүү” гэх зэрэг үг цөөнгүй байна.

Жилийн дөрвөн улиралд цаг уурын хүнд хэцүү нөхцөлд таван хошуу малаа адуулсаар ирсэн монголчуудын хувьд нохой нь хол ойроос ойртсон хүн амьтныг соргогоор мэдэрч эзэндээ мэдээлэх, сүрэг малыг нь араатан амьтнаас хамгаалах зэрэг нэн тустай амьтан юм. Тиймээс монголчуудын дунд “Муу малчнаас сайн хоточ нохой дээр” гэх үг бий. Ийнхүү нохой нь хүний нөхөр болсон ойрын амьтан тул нүүдэлчид түүний дуу авианаас янз бүрийн дохиог мэдэрч, ашигласаар ирсэн юм. Тийм ч учраас нохойны дуугарахыг “хуцах, улих, гаслах, архирах, гийнах, гийналдах, гангинах, гангиналдах, гингэнэх, гонгинох, яр хийх, яр яр хийх, ган хийх, ган ган хийх, хар хийх, хар хар хийх, хүг хүг дуугарах, боргох” гэх зэргээр нэрлэн тэмдэглэж иржээ. Ийнхүү монгол хэлнээ мал амьтны дуу авиаг дуурайн дүрсэлсэн үг хэллэгийг хүснэгтээр тайлбарлан харуулбал,

Хүснэгт 3. Мал, тэжээмэл амьтны дуу авианы нэр

Мал, тэжээмэл амьтны дуу авианы нэр	Тайлбар	Мал, тэжээмэл амьтны дуугарах үйлийн нэр
<i>ан</i>	тэмээний урхирах дуу	
	тэмээний үргэлжилсэн байдлаар дуугарах	<i>буйлах</i>
	тэмээний огцом, үе үе чангаар дуугарах	<i>орилох</i>
	тэмээ мөгөөрсөн хоолойгоороо эхэр татах мэт дуугарах	<i>хүрхрэх /буур/</i>
<i>ий ха ха, ин хин, ин цан</i>	адууны дуу	<i>янцгаах</i>
	адууны ижилдэж нийлэх, ижлээсээ хоцрох холдохдоо хамраараа дуугарах	<i>янцгаах</i>
	адууны янцгаах мэт хүхтнэн дуугарах	<i>үүрсэх</i>

<i>хур</i>	үргэдэг морины хамрын дуу	
<i>тур</i>	морины тургих дуу	
<i>өмбүү, мөн мэн</i>	үхрийн ижлээ харан урт урт дуугарах	<i>мөөрөх</i>
	бухын ороо нь орон хангинан дуугарах	<i>урамдах</i>
	сарлаг хамраараа дуугарах	<i>хахихрах</i>
<i>май май</i>	хонь ижлээсээ холдох хоцрохдоо цангинан царгин дуугарах	<i>майлах</i>
	хонь таргалсан, хэвтсэн үедээ дуугарах	<i>яраглах</i>
<i>май май</i>	ямаа шингэн дуугаар дуугарах	<i>майлах</i>
	ямаа хамраараа үе үе дуугарах	<i>тургих</i>
<i>хав, хав хав</i>	нохойн үе үе дуугарах дуу	<i>хуцах</i>
<i>хау хау</i>		
<i>хөв хөв</i>	нохой дурамжхан дуугарах дуу	
<i>яр яр</i>	нохой тасралтгүй хуцах	<i>яр яр хийх</i>
<i>ган ган</i>	нохойн гангинах дуу	<i>ган гэх</i>
<i>ган</i>	нохойн огцом нэг дуугарах дуу	<i>ган ган хийх</i>
	нохой сулхан гаслах дуу	<i>гийнах, гангинах</i>
	олон ноход харилцан гангинах	<i>гангиналдах</i>
	нохой чоно мэт урт урт дуугарах	<i>улих</i>
	нохой зөөлөн дорой дуугаар, тодорхойгүй авиа гарган дуугарах	<i>гингэнэх</i>
	нохой хэвтэх үедээ үе үе дуугарах	<i>архирах</i>
	нохой өвдсөн үедээ дуугарах	<i>гаслах</i>
<i>ган ган</i>	нохойн гангинах дуу	<i>ган гэх</i>
<i>ган</i>	нохойн огцом нэг дуугарах дуу	<i>ган ган хийх</i>
	нохой тасралтгүй ихээр хуцах	<i>боргоох</i>
<i>миа миа</i>	муурын дуугарах дуу	
	нялх амьтан дуугарах	<i>гийналдах</i>
	гахайны хоолой хохинон дуугарах	<i>хохтнох</i>

Хүснэгт 4. Мэлхий, хорхой, ялаа, батгана, царцаа зэрэг амьтны дуу авианы нэр

Жижиг амьтны дуу авианы нэр	Толь бичгийн тайлбар	Жижиг амьтны дуугарах үйлийн нэр
<i>вар</i>	мэлхий зэрэг амьтны дуугарах чимээ	<i>вааглах</i>
<i>вааг вааг</i>	мэлхий дуугарах дуу авиа	
<i>вар ир</i>	мэлхийн цугаар дуугарах дуу	
<i>жир жир</i>	олон хүрэлзгэнэ жигүүр хөдөлгөх дуу	
<i>час час</i>	хулганын дуугарах дуу	<i>чишгэрэх</i>
	зурам дуугарах дуу	<i>шогширох</i>
	царцаа дуугарах	<i>царгих</i>

<i>сар сар</i>	царцаа нисэх дуу	
	голио дуугарах	<i>гоиширох</i>
	олон амьтны бүдүүн битүү дуу гарах	<i>дүнгэнэлдэх</i>
	батгана, зөгий, хэдгэнэ дуугарах	<i>дүнгэнэх</i>
<i>ян ин</i>	ялаа, шумуул дуугарах	<i>шунгинах</i>

Эндээс харахад мэлхий, царцаа, хулгана зэрэг бичил амьтдын дуу авиаг монгол хэлэнд тэмдэглэх тэр тусмаа авиа дуурайх үгээр илэрхийлэх нь ховор байна.

Амьтдын дуу авиаг монгол хэлэнд дуурайн тэмдэглэхдээ нэг удаа дуугарах дуу авиаг нэг үет авиа дуурайх үгээр, тодорхой давтамжтай дуугарах дуу авиаг нь давтсан авиа дуурайх үгээр тэмдэглэхээс гадна авиа дуурайх язгуур дээр үйл үг бүтээх дагавар залган амьтдын дуугарах үйлийн нэрийг бүтээсэн байна. Энэхүү дагавар залгах үзэгдлийг эрдэмтэн М.Базаррагчаа “*май-л, мөө-р, гаага-л, гуаг-л, буй-л, гууг-л, мяу-л*” зэрэг цөөн хэдэн авиа дуурайх үгийн язгуур нь амьтнаас гарах дуу авиа юм. Энэ нь бодвол “аа, уа, уу, үү” зэрэг авиа өөр хоорондоо сэлгэж, утгын нарийн ялгаа бүхий үг үүссэн байх. Иймэрхүү авиа дуурайх үгст “гийн гоо- (гийнгоолох), ян-ц-гаа (янцгаах), гийнах” зэрэг үгс хамарч болно. Мөн “*хай-л, уй-л, аа-хи-л, уу-хи-л*” зэрэг үгс нь “*хай, хай, уй, уй, аа, уу*” гэсэн авиа дуурайх үгээс үүссэн байна гэж тайлбарласан байдаг. (М.Базаррагчаа, 1987:97)

Орчин цагийн монгол хэлний авиа дуурайх язгуур нь үндсэн хоёр үүрэгтэй (Ц.Өнөрбаян, 2000:139). Үүнийг амьтны дуу авиа дуурайх үгээр жишээлэн авч үзье.

Авиа дуурайх үг нь өгүүлбэрт үйл үгийн өмнө язгуур давтаж, хоршиж тухайн үйл хөдлөлийн болц байдлыг заадаг бөгөөд, ингэж давтаж хоршихдоо нэг бол тухайн дуу авиа олон удаа давтагдах болц байдлыг, эсвэл тэр дуу авиаг үүсгэгч эзэн бие олон болохыг тус тус заадаг. Тухайлбал:

ган - нохойны огцом нэг дуугарах дуу /нэг удаа/

ган ган - нохойны гаслан ганганах дуу /олон удаа давтагдах/

ган ган - галуу шувуу уйтгартай дуугарах дуу /олон удаа давтагдах/

ган гун - олон усны шувууд алсад ганганан дуугарах /эзэн бие олон/ гэх мэт.

Дуу авиа дуурайх язгуурын өөр нэг үүрэг нь дагавар залгаж үйл үг бүтээх явдал юм. Дуу авиа дуурайх язгуурт дагавар залгаж тухайн язгуураар тэмдэглэгдэж байгаа дуу авиа үүсэх явцыг заасан үйл үг бүтээдэг ба ингэхдээ тухайн дуу авианы үргэлжлэх хугацаа (удаан, хоромхон) болц байдал (давтагдах)–ыг ялган заах шинжтэй. Жишээлбэл,

ган+гина= гангинах /нохой сулхан гаслах дуу/

май+л= майлах /хонь, ямаа дуугарах дуу/

гуаг+л= гуаглах /хэрээ шувуу дуугарах дуу/

мөө+р=мөөрөх /үхрийн дуугарах дуу/ гэх мэт.

Хэлний авиа дуурайх язгуурын авианы бүтэц, бүрэлдэхүүнд ерөнхий ялгамж

тодорхой илэрдэг болохыг судалсан эрдэмтэн Ц.Өнөрбаян ард түмнүүдийн зан заншил, эрхэлдэг аж ахуй, амьдарч байгаа байгаль орчин зэргээс шалтгаалж зарим хэл адгуусан амьтны, зарим нь байгалийн элдэв үзэгдлийн дуу авиаг тус тус нарийн тусган дуурайсан язгуур үгээр илүү баялаг байдаг гээд, монгол хэлний авиа дуурайх язгуурын нэлээд нь адгуусан амьтны дуу авиаг дуурайсан байна (Ц.Өнөрбаян, 2000:117) гэсэнтэй адилаар монгол хэлэнд амьтдын дуу авиаг дуурайсан үг элбэг байгаа нь энэхүү судалгаагаар харагдаж байна. Монгол хэлний нэгэн адилаар солонгос хэл нь амьтдын дуугарах дуу авиаг хэлэндээ хэр их, хэрхэн тэмдэглэдэг болохыг сонирхон судалж үзлээ.

2. Солонгос хэлний амьтдын дуугарах дуу авианы нэр

Солонгос хэлний “Эх хэлний стандартад нийцсэн их толь бичиг (표준국어대사전 [pyojun gug-eo dae sajeon])”-т ямар нэг юмны дуу чимээг дуурайсан үгийг авиа дуурайх үг (의성어 [uiseong-eo]), ямар нэг юмны хэлбэр дүрс болон үйл хөдлөлийг дүрсэлсэн үгийг дүрс дуурайх үг (의태어 [uitae-eo]) гэж тодорхойлсон байдаг. Солонгос хэлэнд авиа дуурайх, дүрс дуурайх үгийг эрдэмтэд “음성상징어 [eumseong sangjing-eo] авиа бэлгэдлийн үг, 흥내말 [hyung naemal] дуурайх үг, 시늉말 [sinyung mal] даган дуурайх үг, 상징어 [sangjing-eo] бэлгэдлийн үг, 상징부사 [sangjing busa] бэлгэдлийн дайвар үг” гэх мэт олон янзаар нэрлэн өөр өөрсдийн санал, тодорхойлолтуудыг дэвшүүлж байсныг эрдэмтэн Chae Wan (채완, 2003:15-19) нэгтгэн судалгааны тоймыг гаргажээ. Үүнээс авиа дуурайх үгийн тодорхойлолтоос дурдвал, Yun Hui Won (윤희원:1993) Авиа дуурайх үг нь байгалийн дуу чимээг дуурайн дагаж үүссэн үг гээд, эдгээр үгс нь тухайн хэлнийхээ авиа зүйн тогтолцооноос хамааран авиагаар илэрхийлэгдэнэ гэж; Nam Pung Hyeon (남풍현:1993) Ямар нэг юмны дуу авиаг дуурайсан үгийг авиа дуурайх үг, ямар нэг юмны хэлбэр байдлыг дуурайсан үгийг дүрс дуурайх үгс гэж дуурайх үгийг ялган тодорхойлж; Pak Dong Geun (박동근:1997) Байгаль, ертөнцийн дуу авиаг түүнтэй адилхан авиагаар дуурайсныг дуу авиаг дуурайх үг гэж нэрлэснийг; Sin Jung Jin (신중진:1998) Авиа дуурайх, дүрс дуурайх үгс нь дуу авиа болон хэлбэр байдлыг хэлний хэлбэрээр даган дуурайн илэрхийлж, тухайн хэлний авианы тогтолцоонд харьяалагдаж буй тогтсон ангилал болох гийгүүлэгч, эгшгийг сэлгэсэн ч утгаа өөрчлөлгүй ярианы өнгө аясаар л ялгагдаж болох бие даасан үг юм гэж тус тус тодорхойлжээ.

Харин эрдэмтэн Chae Wan “Байгалийн ба зохиомол бүхий л дуу чимээг тэмдэглэх юм уу дүрслэхийн тулд тухайн дуу чимээтэй хамгийн төстэй авиагаар тэмдэглэсэн үгийг авиа дуурайх үг хэмээн тодорхойлоод, нохой хуцах дуу авиаг “멍멍/경경/왁왁 [meong meong/keong keong/wal wal]” гэх авиа дуурайх үгээр шууд тэмдэглэж болно гэжээ.

Солонгос хэлэнд амьтдын дуу авиаг дуурайн тэмдэглэдэг үгийг дуурайх үгийн тайлбар толиос шүүн түүвэрлэхэд голдуу язгуураа давтсан хэлбэртэй нь

дийлэнх байв. Ингэж язгуураа давтах нь тухайн амьтны дуу авианы давтамжийг илтгэдэг. Тухайлбал,

Хүснэгт 5. Солонгос хэлний амьтдын дуугарах дуу авианы нэр

Амьтдын дуу авиаг дуурайсан үгс	Толь бичгийн тайлбар
깹깹, 쾡쾡, 깨깹깨깹 [kkaeng-kkaeng, kaeng-kaeng, kkae-gaeng-kkaegaeng]	гөлөг хуцах
컹컹, 멍멍 [meong-meong]	нохой хуцах
아웅아웅 [a-ong-a-ong] 야웅야웅 [ya-ong y-aong]	муур дуугарах
꿀꿀 [ggul-ggul]	гахай дуугарах
히힃 [hi-hing]	морь дуугарах
음매 [eum-mac], 음메 [eum-me]	үхэр, тугал дуугарах
매 [mac]	хонь ямааны майлах
개골개골 [gaegol-gaegol],	
맹꽁맹꽁 [maengkkong-maengkkong]	мэлхий дуугарах
어흥 [eo-heung]	бар дуугарах
짹짹 [jjik-jjik]	хулгана дуугарах
삐꾸 [bbeogguk]	хөхөө дуугарах
짹짹 [jjack-jjack]	болжмор дуугарах
꼬꼬댁 [ggo-ggo-daek]	азарган тахиа дуугарах
꼬끼오 [ggo-ggi-o]	эм тахиа дуугарах
꾸르륵꾸르륵 [kkureureuk-kkureureuk]	тахиа дуугарах
각각 [ggak-ggak] 까옥까옥 [gga-okgga-ok]	хэрээ дуугарах
꺽꺽 [ggwack-ggwack]	нугас дуугарах
피꿀피꿀[kkoekkol-kkoekkol]	гургалдай дуугарах
귀뚜라미 [kkwittul-gwittul]	хүрэлзгэнэ дуугарах
끼룩끼룩 [kkiruk-kkiruk]	галуу дуугарах
구구 [gu-gu]	тагтаа дуугарах
삐약삐약 [bbi-yak bbi-yak]	дэгдээхэй дуугарах
맴맴 [maem maem]	голио дуугарах
붕붕, 윙윙 [bung bung, wing wing]	зөгий дуугарах
윙윙, 윙윙 [waeng waeng, wing-wing]	шумуул дуугарах
쓰르륵쓰르륵 [sseureureuk-sseureureuk]	царцаа дуугарах

Дээрх амьтдын дуу авиаг дуурайсан авиа дуурайх үгсээс нохой, муурын дуугарах дуу авианы нэрийг жишээлбэл,

1. 두 마리 개가 똑같이 고기를 덩석 잡았고, 서로 빼앗기지 않으려고 싸움을 벌였어요. "멍멍! 내가 먼저 보았어. 이거 봐!" (피 많은 여우)

[du mari gaega ttoggat-i gogireul deobseog jab-adgo, seoro ppaegasgiji anh-eu-ryeogo ssaum-eul beor-yeoss-eoyo. "meongmeong! naega meonjeo boass-eo. igeo nwa!"] (Kkoe manh-eun yeou)

Хоёр нохой нэгэн зэрэг ухасхийж мах булаалцан архиалдана. мон мон, би

эхэлж энэ махыг харсан. Наадхаа тавь!...

2. 아옹아옹! 고양이 [ya-ong ya-ong! go-yang-i]
 눈이 반짝반짝, 귀가 쫑긋 [nuni banjag banjag, gwigajjunggeud]
 고양이가 고개를 가우뚱한 채 [goyang-iga gogaereul gyauttunghan chae]
 색시처럼 얇전히 앉아 있어요. [saegsicheoreom yamjeonhi anja isseoyo]

Ya-ong-ya-ong! Муур

Нүд нь гялалзаж, чих нь сэртэс хийн

Махаа зуусан чигтээ

Ялдамхнаар томоотой суулаа гэх мэт.

Солонгос хэлэнд эгшгийг хэлний өргөгдөх байдал буюу хэлний оролцоо, өгүүлэх эрхтний чангарах байдлаар нь эр, эм гэж ангилж арга билгийн чанараар харилцан эсрэгцэх утга гаргадаг. (Chae Wan 2003:76) Өөрөөр хэлбэл, солонгос хэлний эр эгшиг “아[a], 오[o]” нь гэрэлтэй, хөнгөн, жижиг, хурц, нимгэн, хурдан, хүчтэй, цэвэр, тунгалаг гэх мэт үгийн өнгө аясыг илтгэдэг бол эм эгшиг “어[eo], 우[u]” нь эсрэгээрээ харанхуй, хүнд, том, мохоо, удаан болхи, сул дорой, бохир булингартай гэх мэт өнгө аяс илтгэдэг. Харин дээрх хүснэгтээс ажиглавал, амьтдын авиа дуурайх үг эгшиг сэлгэх үзэгдэл төдийлөн ажиглагдахгүй байгаа бол гийгүүлэгч сэлгэх үзэгдэл ажиглагдаж байна. Тухайлбал, гөлөгний хуцах дуу авиаг 꺽꺽[kkaengkkaeng], 꺽꺽[kaengkkaeng] гэх хүчтэй сул гийгүүлэгч “ㄱ[kk]”-ээс чанга гийгүүлэгч “ㅋ[k]” болж сэлгэснээр гөлөг улам чанга дуугаар хуцах утгыг илтгэж байна. Учир нь солонгос хэлэнд гийгүүлэгчийг амнаас гарч буй хийн түрэлтийн хүч болон өгүүлэхийн эрхтний чангарал сулралаар нь сул гийгүүлэгч 평음 [pyeong-eum], хүчтэй сул гийгүүлэгч 경음 [gyeong-eum], чанга гийгүүлэгч 격음 [gyeog-eum] гэж ангилдаг. Энэ нь авианы утгын ялгамжийг илэрхийлдэг бас нэг хүчин зүйл болдог ба тухайн дуу чимээг ялган үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, гийгүүлэгч авиа чангарч хатуурах тусам ярианы өнгө аяс, тухайн дуу авиа нэлээд хүчтэй сүржин болдог. Солонгос хэлэнд авиа дуурайх үгийн гийгүүлэгч сэлгэх үзэгдэл нь гийгүүлэгч авианы гол онцлог болох дээрх гуравласан тогтолцоо буюу сул, хүчтэй сул, чанга гийгүүлэгчийн хооронд үүсдэг.

Солонгос хэлэнд авиа дуурайх болон дүрс дуурайх үгийн язгуурт дагавар залган шинэ үг бүтээх боломж их байдаг. Ингэхдээ авиа дуурайх, дүрс дуурайх үгийн аль алинд дан юм уу давтсан хэлбэртэйд “-하다 [-hada], -대다 [-daeda], -거리다 [-georida], -이다 [-ida]” дагавар залгаж үйл үг, тэмдэг нэр бүтээдэг. Амьтдын дуугарах дуу авиа дуурайсан давтсан язгуурт ихэнхдээ “-거리다 [-georida]” дагавар залган үйл үг бүтээдэг. Тухайлбал, 짹짹 [jjig jjig] гэх хулгана, шувуу зэргийн давтамжтай дуугарах дуу авиа дуурайсан язгуурт -거리다 [-georida] дагавар залгаж =짹짹거리다 [jjig jjiggeorida] гэх хулгана дуугарах, шувуу дуугарах гэсэн үйл үг бүтээдэг.

Солонгос хэлэнд авиа дуурайх үгийн язгуурт дагавар залган үйл үг, тэмдэг нэр бүтээхээс гадна “-이 [-i], -기 [-gi], -리 [-ri]” дагавар залгаж үүсмэл нэр үг бүтээдэг. Тухайлбал, гахайны дуугарах дуу авиа “꿀꿀 [kkul kkul]”, нохой хуцах

дуу авиа “멍멍 [meong meong]”, муурын дуугарах дуу авиа “야옹 [ya-ong]” зэрэг авиа дуурайх үгэнд “ㅇ [i]” дагавар залган “꿀꿀ㅇ [kkul kkul-i]” гэж гахайг, “멍멍ㅇ [meong meong-i]” гэж нохойг, “야옹ㅇ [ya-ong-i]” гэж муурыг нэрлэдэг. Амьтдын дуу авиа дуурайх язгуурт нэр үг бүтээх дагавар залган тухайн амьтдыг нэрлэх үзэгдэл солонгос хэлэнд түгээмэл бий. Үүнийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 6. Солонгос хэлний авиа дуурайх язгуурт “ㅇ [i]” дагавар залган нэр үг бүтээх нь

Авиа дуурайх үг	Авиа дуурайх үгийн утга	Амьтдын нэр
꿀꿀 [ggulggul]	гахайны дуу авиа	꿀꿀ㅇ [ggulggul-i]-гахай
멍멍 [meongmeong]	нохой хуцах дуу авиа	멍멍ㅇ [meongmeong-i]- нохой
야옹 [ya-ong]	муурын дуу авиа	야옹ㅇ [ya-on-i] -муур
삐깍 [bbeogguk]	хөхөө шувууны дуу авиа	삐꾸기 [bbeogguki] -хөхөө
개골개골 [gaegolgaegol]	мэлхийний дуу авиа	개구리 [gaeguri] - мэлхий
어흥 [eoheung]	барын хүрхрэх дуу авиа	어흥ㅇ [eoheun-i] -бар
피꿀피꿀 [ggoeggulggoeggul]	гургалдай шувууны дуу авиа	피꼬리 [ggoegguri]

Амьтдын дуу авиаг дуурайсан авиа дуурайх үгээр амьтдыг нэрлэх нь ялангуяа хүүхдийн ой ухаанд амархан тогтоогддог. Үүний нэгэн адилаар монгол хэлэнд нохойг “хөв хөв”, муурыг “мяу” үхрийг “өмбүү”, хурга, ишгийг “май май” гэх мэтээр хүүхдүүд нэрлэдэг бол солонгос хэлэнд амьтдын дуу авиаг дуурайсан авиа дуурайх үгэнд нэр үг бүтээх “-ㅇ (-i), -기 (-gi), -리 (-ri)” гэх мэт дагавар залган амьтдын нэрийг нэрлэдэг онцлогтой байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаандаа амьтдын дуу авиаг монгол хэлэнд хэрхэн тэмдэглэдэг болохыг судлаад зогсохгүй солонгос хэлэнд амьтдын дуугарах дуу авианы нэрийг хэрхэн тэмдэглэдэг болохыг ажиглалаа. Ингэхдээ хоёр хэлний дуурайх үгийн тайлбар толийг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглаж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Амьтдын дуугарах дуу авианы нэрийг хоёр хэлний тайлбар тольч бичиг, дуурайх үгийн тайлбар толиос шүүн түүвэрлэхэд монгол хэлэнд ойролцоогоор 100-аад үг байсан бол солонгос хэлэнд 30-аад үг байлаа. Энэ нь монгол хэлэнд амьтдын дуугарах дуу авиаг хэлэнд тэмдэглэх байдал солонгос хэлийг бодвол харьцангуй баялаг байдгийг илтгэж байна. Энэ нь монголчуудын нүүдлийн соёл иргэншлээс шалтгаалж байгаль эх дэлхийтэйгээ харьцах нь илүү ойр байдагтай холбоотой гэж үзэх боломжтой байна.
- Монгол хэлэнд амьтдын дуу авианы нэрийг ан гөрөөсний, шувууны, мал, тэжээмэл амьтны, мэлхий, ялаа зэргийн жижиг амьтны гэж 4 ангилаад амьтдын дуу авиа дуурайх үг болон дуугарах үйлийн нэрийг түүж үзэхэд ангилал тус бүрд авиа дуурайх үг судалгааны хэрэглэгдэхүүн болохуйц

элбэг байсан ба эдгээрээс шувууны дуу авианы нэр, дуугарах үйлийн нэрийг бусад амьтдын дуу авианаас илүү өргөн далайцтай тэмдэглэдэг болох нь уг судалгаагаар ажиглагдлаа. Энэ нь жигүүртэн шувуу бусад амьтдаас хамгийн уянгалаг дуу авиа гаргадаг учир монгол хэлэнд шувууны дуу авиаг олон янзаар тэмдэглэдэг төдийгүй уран зохиолын уран яруу дүрслэл зэрэгт их хэрэглэдэг онцлогтой гэж үзэж болохоор байна.

- Монгол, солонгос хэлний дан язгуураас бүтсэн авиа дуурайх үг нь тухайн дуу чимээний нэг удаагийн хоромхон хугацаанд дуугарахыг, язгуураа давтсан авиа дуурайх үг нь тухайн дуу чимээний үргэлжлэх, давтагдах байдлыг илтгэдэг нийтлэг шинж байна. Харин монгол хэлэнд эгшиг авиаг сэлгэж олон амьтдын нарийн бүдүүн, өтгөн шингэн янз бүрийн дуу холилдсон шуугианыг дүрсэлдэг бол солонгос хэлэнд эгшиг авиаг сэлгэж, тухайн дуу авиа үүсгэгч биеийн овор хэмжээг ялгаж заадаг онцлог байна.
- Монгол хэлэнд авиа дуурайх язгуурт үйл үг бүтээх тогтсон хэдэн дагавар залгадаг ба эдгээрээс амьтдын дуу авиа дуурайх язгуурт үйл үг бүтээх дагавар залгаж “архирах, жиргэх, гуаглах, жиргэх, хүхтнэх, шагшрах, мөөрөх” гэх мэт үйл үг бүтээдэг бол солонгос хэлэнд авиа дуурайх язгуурт залгадаг тогтсон дагавар байхгүй ч дуурайх үгийн язгуурт “-하다 [-hada], -거리다 [-georida], -대다 [-daeda], -오다 [ida]” гэх 4 дагаврыг залгаж үйл үг бүтээдэг онцлогтой. Эдгээр 4 дагавар авиа дуурайх үгээс гадна дүрслэх үгийн язгуурт мөн залгаж үйл үг, тэмдэг нэр бүтнэ.
- Амьтдын дуу авиаг дуурайсан авиа дуурайх үгээр амьтдыг нэрлэх нь ялангуяа хүүхдийн ой ухаанд амархан тогтоогддог. Үүний нэгэн адилаар монгол хэлэнд “хөв хөв, “мяу, өмбүү, май май” гэх мэт авиа дуурайх үгээр нь шууд нэрлэдэг бол солонгос хэлэнд авиа дуурайх үгээр нь шууд нэрлэх бус харин амьтдын дуу авиаг дуурайсан авиа дуурайх язгуурт нэр үг бүтээх дагавар залган амьтдыг нэрлэдэг онцлогтой байна.

Монгол, солонгос хэл нь авиа дуурайх үгээр маш баялаг бөгөөд, энэхүү судалгаандаа зөвхөн авиа дуурайх үгийг ан амьтан дээр тулгуурлан амьтдын дуугарах дуу авиаг хоёр хэлэнд хэрхэн тэмдэглэн хэрэглэдэг болохыг тайлбар толиос түүж судалсан бөгөөд, цаашид зөвхөн дуу авиаг бус хүн, амьтан, юмс, үзэгдлийн үйл хөдлөл, гадаад төрх байдал, овор хэмжээг дүрслэх дүрс дуурайх үгийг хамт судалж улмаар хоёр хэлний дуурайх үгийг харьцуулан судлах хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

Монгол хэлний баялаг үг хэллэг болох эдгээр авиа дуурайх, дүрс дуурайх үгийг орчин цагийн зохиолчид зохиол бүтээлдээ түлхүү хэрэглэх нь хэлний дархлаанд чухал үүрэгтэй юм. Учир нь солонгос хэлэнд амьтдын авиа дуурайсан үгийг ялангуяа хүүхдийн зохиолд өөрөөр хэлбэл хүүхдийн шүлэг, дуунд түлхүү хэрэглэдэг онцлогтой. Харин монгол хэлэнд ийм баялаг байгаа амьтдын дуугарах дуу авиа дуурайх үгийг хүүхдийн дуу, шүлгийн бүтээлдээ орчин цагт хэрэглэх

байдал хязгаарлагдмал харагддаг. Энэхүү судалгаанд багтаасан ан амьтны дуу авиаг төдийгүй хүн, амьтны үйл хөдлөл, гадаад төрх заасан дүрс дуурайх үгсийг хүүхдийн зохиолчид зохиол бүтээлдээ болон бага ангийн монгол хэл, дуу хөгжмийн хичээлийн сурах бичигт арвин хэрэглэх нь монгол үг хэллэгээ үр хойчдоо үлдээх үнэт зүйл болохоос гадна өнөөгийн хэл шинжлэлд чухал хэмээгдэж буй хэрэглээний хэл шинжлэлд зохих хувь нэмрээ өгч чадна гэж үзэж байна.

Abstract:

The sounds of objects and phenomena in the real world are expressed in language using onomatopoeic words. In this process, each language represents a specific natural sound differently, which is closely related to how the sound is perceived and experienced. For example, the sound of a dog barking is expressed as “xav xav” in Mongolian, “zav zav” in Russian, “わんわん [wan wan]” in Japanese, and “멍멍 [meong meong]” in Korean.

Onomatopoeic words are among the first words children learn and share characteristics similar to early language acquisition patterns. Therefore, young children frequently use onomatopoeic words, and it is common for them to name animals based on the sounds they make.

Based on the Mongolian explanatory dictionary and onomatopoeic word dictionary, I have analyzed and organized how animal sounds are represented using onomatopoeic words in the Mongolian language. Additionally, during this research process, I observed how animal sounds are expressed in the Korean language, analyzing their structure, types, and unique characteristics.

In Mongolian, onomatopoeic words representing animal sounds appear in either singular or repeated forms. These words not only indicate a single sound or a continuous sound made by the animal, but they also have the feature of switching between different sounds to represent various sources of the sound.

Additionally, in Mongolian, onomatopoeic words can form verbs by adding verb suffixes to represent animal sounds. In contrast, the representation of animal sounds in Korean is less frequent compared to Mongolian, and when used, it is often in the form of repeated onomatopoeic words to express animal sounds.

Ном зүй

А. Монгол хэлээр

Базаррагчаа, М. (1987). *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. Улаанбаатар: Ардын Боловсролын Яамны хэвлэх. [Bazarragchaa, M. *Mongol kelnii avia selgeh yos*. Ulaanbaatar: Ardiin Bolovsroliin Yamnii hevleh. 1987.]

Барайшир, Ш. (1970). *Орчин цагийн монгол хэлний дайвар үг, докторын зэрэг горилсон бүтээл*, Улаанбаатар: МУБИС. [Baraishir, Sh. *Orchin tsagin mongol kelnii daivar ug, doktoriin zereg gorilson buteel*. Ulaanbaatar: MUBIS. 1970.]

- Нарантуяа, Ш.** (2021). *Дүрслэх үгийн тайлбар толь*. Улаанбаатар: Удам соёл ХХК. [Narantuya, Sh. *Dursleh ugiin toli*. Ulaanbaatar: Udam soyol LLC. 2021.]
- Өнөрбаян, Ц.** (2000). *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар: МУБИС. [Unurbayan, Ts. *Orchin tsagiin mongol helnii uil ug buteh yos*. Ulaanbaatar: MUBIS. 2000.]
- Өнөрбаян, Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар: МУБИС. [Unurbayan, Ts. *Orchin tsagiin mongol helnii ug zui*. Ulaanbaatar: MUBIS. 2000.]
- Төмөртоогоо, Д.** (2004). *Хэлишинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар: Адмон ХХК. [Tumurtogoo, D. *Helshinjelelin ner tomiyonii huraangui toli*. Ulaanbaatar: Admon. 2004.]
- Соаре Василе,** (1997). *Орчин цагийн монгол хэлний дүрслэх үгийн онцлог*. Улаанбаатар: ШУА. [Soare Vasile. *Orchin tsagiin dursleh ugiin ontslog*. Ulaanbaatar: SHUA. 1997.]
- Цэвэл, Я.** (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [Tsevel, Ya. *Mongol helnii tovch tailbar toli*. Ulaanbaatar: Munhin useg LLC. 2013.]
- Б. Англи ба бусад хэлээр*
- И.А. Бодуэн де Куртенэ,** (1963). *Избранные труды по общему языкознанию* Т.И. Москва. [I.A. Boduen de Kurtyene. *Izbrannie trudi no obshemu yazikoznaniyu* T.I. Moskva. 1963.]
- Г.И.Рамстедт,** (1957). *Введение в алтайское языкознание*, Москва. [G.I. Ramstedt. *Vvedenie v altaiskoe yazikoznanie*, Moskva. 1957.]
- 이기원.** (2007). *한국어의 의성어와 의태어*. 한국문화사. [I Gi won. *Hangug-eoui uiseong-eowa uitaeo*. Hangugmunhwasa. 2007.]
- 채완.** (2003). *한국어의 의성어와 의태어*. 서울대학교출판부. [Chae wan. *Hangug-eoui uiseong-eowa uitaeo*. Seouldaehaggyo chulpanbu. 2003.]

В. Цахим эх сурвалж:

Retrieved from <https://mongoltoli.mn/>

Retrieved from <http://www.touristinfocenter.mn/cate11.aspx>

Retrieved from <https://stdict.korean.go.kr/>

Retrieved from <https://roman.cs.pusan.ac.kr/>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.